



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/002/НА-СТА-ТӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: С.Нацагдорж Утас: 260512 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn</p> <p>Аудитор: Б.Эрдэнэзул Утас: 261628 Цахим хаяг: erdenezulb@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн захирал : С.Тунгалаг Утас: 70001778 Цахим хаяг: info@imkaudit.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

МОНГОЛ ГАЗРЫН ТОС
БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР ТӨХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.АЛТАНЦЭЦЭГ
ТАНАА

2025.03.28 № 07/1075
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн нийт 590.9 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Тайлант онд 6 байгууллагад өгөх нийт 231.3 сая төгрөгийн өр төлбөр, 12 байгууллагаас авах нийт 336.9 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
- Тайлант онд сургалт зохион байгуулах ажлын гэрээ байгуулаагүй 2 байгууллагад сургалтын зардалд нийт 17.5 сая төгрөгийг шилжүүлсэн зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК, Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний 339 дүгээр анги хамтран Дорноговь аймгийн Сайншанд суманд Газрын тосны үйлдвэрийн хотхоны 287 айлын орон сууцны барилга барих гэрээг 2019 онд байгуулсан боловч барилга угсралтын ажил зогсонги байдалд орсноор Хөгжлийн банканд төлөх зээлийн хүүгийн зардалд тайлант онд 3,786.4 сая төгрөгийг бүртгэж, үр ашиггүй зардал нэмэгдсээр байна. Барилгын ажлыг 2025 онд дуусгаж ашиглалтад оруулах төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр гэрээлэгч талууд хамтран баталсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Засгийн газрын 2021 оны 266 дугаар тогтоолоор газрын тосны хайгуулын Давст ХХХI талбайг Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-д олгосон ч өөрсдийн үйл ажиллагааны орлогоор төслийг санхүүжүүлэх боломжгүй байгаагаас хөрөнгө оруулалтын зардал ихээхэн шаардах өндөр эрсдэлтэй газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт татахаар олон улсын компаниудад хамтран ажиллах урилга хүргүүлсэн боловч санал ирээгүй байна.

Бусад мэдээлэл

Засгийн газраас Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн үйл ажиллагааг хэвийн явуулах, түүхий эдээр тасралтгүй хангагдах боломжийг бүрдүүлэхээр Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, хөрөнгө оруулагч компанийг бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгч талтай адил аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөгдөх нөхцөлийг бүрдүүлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд Аудитын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,966,920,880.95	2,990,011,847.07
1.1.2	Дансны авлага	97,599,059.05	707,698,164.40
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	1,076,057,768.96	1,001,979,720.17
1.1.4	Бусад авлага	49,405,983.03	48,420,000.00
1.1.5	Бараа материал	72,177,281.80	8,761,765.18
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	109,041,173,994.65	47,175,904,580.73
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	113,303,334,968.44	51,932,776,077.55
1.2.1	Үндсэн хөрөнгө	500,405,094,732.37	106,758,475,104.80
1.2.2	Биет бус хөрөнгө	9,512,990,500.26	11,128,726,063.80
	Дуусаагүй барилга	-	1,027,137,857,666.01
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	509,918,085,232.63	1,145,025,058,834.61
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	623,221,420,201.07	1,196,957,834,912.16
2.1.1.1	Дансны өглөг	15,172,512,741.95	317,229,951,187.22
2.1.1.2	Цалингийн өглөг	121,172.56	-
2.1.1.3	Татварын өр	17,066,950.00	793,238.56
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	45,954,913,887.51	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	61,144,614,752.02	317,230,744,425.78
2.1.2.1	Урт хугацаат зээл	176,729,650,692.32	191,131,754,278.32
2.1.2.2	Ур хугацаат зээлийн хүү	84,340,940,682.53	110,074,468,050.29
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	345,476,744,857.45	639,194,688,634.70
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	606,547,336,232.30	940,400,910,963.31
2.2	Өр төлбөрийн нийт дүн	667,691,950,984.32	1,257,631,655,389.09
2.3.1	Өмч: - төрийн	10,000,000.00	10,000,000.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	9,384,783,200.00	11,022,738,200.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(53,865,313,983.25)	(71,706,558,676.93)
2.3.9.1	Тайлангийн үеийн ашиг	-	(18,470,386,552.28)
2.3.9.2	Өмнөх үеийн ашиг	(44,470,530,783.25)	(53,236,172,124.65)
2.3.11	Эздийн өмчийн дүн	(44,470,530,783.25)	(60,673,820,476.93)
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	623,221,420,201.07	1,196,957,834,912.16

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	660,616,982.36	1,084,229,791.82
2	Борлуулалтын өртөг	877,272,181.41	728,294,490.75
3	Нийт ашиг(алдагдал)	(216,655,199.05)	355,935,301.07
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүгийн орлого	-	10,921,898.73
8	Бусад орлого	3,467,028.30	3,144,422.70
9	Орлогын дүн	3,467,028.30	14,066,321.43
10	Ерөнхий ба удирдлагын зардал	7,430,826,492.41	11,951,390,724.34
11	Санхүүгийн зардал	-	345,998,427.95
12	Бусад зардал	-	615,779,170.90
12.1	Зардлын дүн	-	12,913,168,323.19
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	15,688,216,143.84	(5,926,127,671.96)
17	Бусад ашиг (алдагдал)	(8,609,801,923.28)	-
17.1	Олз, гарзын дүн	-	(5,926,127,671.96)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(565,600,442.60)	(18,469,294,372.65)
19	Орлогын татварын зардал	918,515,694.35	1,092,179.63
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(1,484,116,136.95)	(18,470,386,552.28)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(1,484,116,136.95)	(18,470,386,552.28)
24	Орлогын нийт дүн	(1,484,116,136.95)	(18,470,386,552.28)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
	Мөнгөн хөрөнгөөс мөнгөн хөрөнгө рүү бичсэн гүйлгээ	-	-
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	497,322,299.78	335,769,924.83
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	465,530,136.60	260,408,924.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	445,000.00	2,667,150.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	31,347,163.18	72,693,850.83
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,025,950,067.12	6,577,641,200.82
1.2.1	Ажиллагчдад төлсөн	2,207,647,557.16	3,174,508,660.73
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	780,882,671.68	816,796,498.43
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	57,041,360.95	80,936,979.42
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	748,312,788.14	979,337,369.61
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	40,950,750.00	69,739,931.78
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	-	22,999,999.97
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	482,526,959.85	602,659,230.44
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	22,509,051.00	50,396,148.80
1.2.9	Бусад мөнгөн зарлага	686,078,928.34	780,266,381.64
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(4,528,627,767.34)	(6,241,871,275.99)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	-	-
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.1.8	Бусад	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,048,390,873.00	8,137,227,155.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	295,500,000.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	5,048,390,873.00	7,841,727,155.00
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
2.2.6	Бусад	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(5,048,390,873.00)	(8,137,227,155.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-

3.1	Мөнгөн орлогын дүн (+)	10,393,810,438.00	14,402,103,586.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	10,393,810,438.00	14,402,103,586.00
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
3.1.4	Бусад	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	-
3.2.5	Бусад	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	10,393,810,438.00	14,402,103,586.00
3.4	Валютын ханшийн зөрүү	-	85,811.11
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	816,791,797.66	23,090,966.12
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,150,129,083.29	2,966,920,880.95
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,966,920,880.95	2,990,011,847.07

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	10,000,000.00	9,384,783,200.00	(52,381,197,846.30)	(42,986,414,646.30)
2	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(1,484,116,136.95)	(1,484,116,136.95)
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
9	2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	10,000,000.00	9,384,783,200.00	(53,865,313,983.25)	(44,470,530,783.25)
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	629,141,858.60	629,141,858.60
11	Залруулсан үлдэгдэл	10,000,000.00	9,384,783,200.00	(53,236,172,124.65)	(43,841,388,924.65)
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(18,470,386,552.28)	(18,470,386,552.28)
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	1,637,955,000.00	-	1,637,955,000.00
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
17	2024 оны 12 сарын 31-р үлдэгдэл	10,000,000.00	11,022,738,200.00	(71,706,558,676.93)	(60,673,820,476.93)

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлтүүд	Х/н	2024 он			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ЭХ ҮҮСВЭР	м.төг	358,464,172.5	305,499,735.6	(52,964,436.9)	85.2
	Нийт ашиг/алдагдал	м.төг	(642,406.7)	355,935.3	998,342.0	(55.4)
	Борлуулсан ажил, үйлчилгээний орлого	м.төг	901,586.0	1,084,229.8	182,643.8	120.3
	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	м.төг	1,543,992.7	728,294.5	(815,698.2)	47.2
	Үйл ажиллагааны бус орлого	м.төг	10,350.0	14,066.3	3,716.3	135.9
	Зээлээр санхүүжих	м.төг	359,096,229.2	305,129,734.0	(53,966,495.3)	85.0
2	Нийт зардал	м.төг	8,578,288.9	12,297,389.2	3,719,100.3	143.4
	Ерөнхий ба удирдлагын зардал	м.төг	5,412,622.5	5,935,443.4	522,820.9	109.7
	Элэгдлийн зардал	м.төг	3,165,666.4	6,361,945.7	3,196,279.3	201.0
	ГВХЗ-ний олз/гарз	м.төг	2,364,565.8	-	(2,364,565.8)	-
	Үйл ажиллагааны бус зардал	м.төг	46,571.9	6,541,906.9	6,495,335.0	14,046.9
	Үйл ажиллагааны бус зардал	м.төг	41,200.0	615,779.2	574,579.2	1,494.6
	ГВХЗ-ний бодит бус гарз	м.төг	5,371.9	5,926,127.7	5,920,755.8	110,317.2
3	Татварын өмнөх ашиг	м.төг	(6,892,351.7)	(18,469,294.4)	(11,576,942.7)	268.0
	Орлогын татварын зардал		-	(1,092.2)	-	-
4	Цэвэр ашиг /алдагдал/	м.төг	(6,892,351.7)	(18,470,386.6)	(11,578,034.9)	268.0
5	Нийт ажиллагсдын тоо (ТУЗ, үндсэн, гэрээт)	хүн	106	106	0	100.0
6	Нийт цалингийн сан	м.төг	3,942,727.3	3,911,618.0	(31,109.3)	99.2
7	Нэг ажилтны дундаж цалин	м.төг	3,099.6	3,075.2	(24.4)	99.2
8	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	м.төг	-	-	-	-
9	Хөрөнгө оруулалт	м.төг	353,000,000.0	298,934,446.7	(54,065,553.3)	84.7
10	Нийт авлага	м.төг	57,040,831.2	1,758,098.0	(55,282,733.2)	3.1
	Дансны болон бусад авлага	м.төг	56,998,576.2	707,698.2	(56,290,878.0)	1.2
	Барьцааны авлага	м.төг	22,255.0	48,420.0	26,165.0	217.6
	НДШ, татварын авлага	м.төг	20,000.0	1,001,979.8	981,979.8	5,009.9
11	Нийт өглөг	м.төг	931,559,369.6	1,257,631,655.4	326,072,285.8	135.0
	Дансны өглөг	м.төг	592,515,078.4	908,731,580.0	316,216,501.6	153.4
	НДШ, Татварын өглөг	м.төг	85,000.0	793.2	(84,206.8)	0.9
	Барьцааны өглөг	м.төг	29,626,858.5	47,693,059.8	18,066,201.3	161.0
	Урт хугацаат зээлийн хүүгийн төлбөр	м.төг	113,449,610.6	110,074,468.1	(3,375,142.5)	97.0
	Урт хугацаат зээл	м.төг	195,882,822.1	191,131,754.3	(4,751,067.8)	97.6

3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 11,851.1 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 11,851.1 сая төгрөгийн 4 алдааг залрууллаа.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус алдагдал 5,889.1 сая төгрөгийг 2024 оны санхүүгийн байдлын тайлангийн эздийн өмчийн хэсэгт, гадаад валютын хөрвүүлэлтийн нөөцөөр бүртгэж тайлагнасан байна.	1	5,889,131.5	-	-	1	5,889,131.5	1	5,889,131.5	-	-	-	-
Санхүүгийн байдлын тайлангийн хуримтлагдсан ашгийн эцсийн үлдэгдлийн дүн нь өмчийн өөрчлөлтийн хуримтлагдсан ашгийн эцсийн үлдэгдлийн дүнгээс 5,143.6 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.	1	5,143,606.6	-	-	1	5,143,606.6	1	5,143,606.6	-	-	-	-
Хяналтын тооллогоор ашиглалтад орсон хотхоны байрыг тохижуулсан 10 нэр төрлийн 326 ширхэг нийт 189.2 сая төгрөгийн анхны өртөгтэй үндсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй байна.	1	189,172.5	-	-	1	189,172.5	1	189,172.5	-	-	-	-
Тайлант оны санхүүгийн байдлын тайланд хойшлогдсон татварын өр төлбөрийг 629.1 сая төгрөгөөр илүү тайлагнасан байна.	1	629,141.9	-	-	1	629,141.9	1	629,141.9	-	-	-	-
Дүн	4	11,851,052.5	-	-	4	11,851,052.5	4	11,851,052.5	-	-	-	-

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

3.2 Аудитаар нийт 590.9 сая төгрөгийн зөрчил илэрснээс 1.3 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 585.7 сая төгрөгийн 2 албан шаардлага хүрч, 3.9 сая төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
МГТБҮ ТӨХХК-ийн захирлын "Захиргааны орон тооны бүтцийг батлах тухай" 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/107 дугаар тушаалаар баталсан Компанийн бүтэц орон тооны жагсаалтад ерөнхий нягтлан бодогчийн орон тоог батлаагүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Худалдан авсан хөрөнгө материалын нягтлан бодох бүртгэлийн бүртгэсэн дүн нь бэлтгэн нийлүүлэгч байгууллагын төлбөрийн цахим системд бүртгэсэн дүнгээс 20 иргэн, байгууллага 159.5 сая төгрөгөөр дутуу, 168 иргэн байгууллага 91,197.5 сая төгрөгийг илүү бүртгэсэн байна.	1	-	-	-	--	--	1	-	-	-	-	-
Шалгагдагч байгууллага нь нийт 6 байгууллагын нийт 231.3 сая төгрөгийн өр төлбөр, 12 байгууллагын нийт 336.9 сая төгрөгийн	1	568,226.1	-	-	1	568,226.1	-	-	-	-	--	-

авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.												
Шалгагдагч байгууллага нь 1 ажилтны цалин хөлсийг тооцоолохдоо 1.3 сая төгрөгийг илүү олгосон байна.	1	1,245.8	1	1,245.8	-	-	-	--	-	--		
Тайлант онд цалин хөлсний тооцооллыг давтан шалгахад нэр бүхий 3 ажилтны албан тушаалын нэршлийг ТУЗ-ийн 11 дүгээр сарын 23-ны өдрийн 20 дугаар тогтоолын дагуу тогтоогоогүйгээс шалтгаалж, 3,881.6 мянган төгрөгийн цалин хөлсийг илүү олгосон байна.	1	3,881.6	-	-	-	-	1	3,881.6	-	--	-	-
Ажил, үйлчилгээ үзүүлэх гэрээгүй 2 ААН-д нийт 17.5 сая төгрөгийг шилжүүлж, сургалтын зардлаар бүртгэж тайлагнасан байна.	1	17,500.0	-	-	1	17,500.0			-	--	-	-
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын "Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай" 2024 оны 205 дугаар тогтоолын дагуу Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын Газрын тос боловсруулах үйлдвэрийн (ЕРС 01) багц ажлын хүрээнд барилгын ерөнхий гүйцэтгэгч Калпатару Прожектс Интернейшнл компаниас төсөл хэрэгжүүлэгчид хүлээлгэн өгөх тоног төхөөрөмжүүд болон тэдгээрийн бууршгүй нөөцийг хүлээлцэх ажлын хэсэг байгуулах тухай 2024 оны	1	-	-	-	-	-	1	-	-	--	-	-

А/52 дугаар тушаалыг хэрэгжүүлээгүйн улмаас нийт 274 нэр төрлийн бууршгүй нөөцийн хөрөнгийг хүлээлцээгүй, нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнаагүй байна.												
Дүн	7	590,853.5	1	1,245.8	2	585,726.1	4	3,881.6	-	-	-	-

3.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 3,649.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс 3,649.8 сая төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Хариуцлага тооцуулах албан шаардлага		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тайлант оны шилэн дансны цахим хуудсыг шалгахад нийт 157 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 149, хугацаа хоцорч мэдээлсэн 6, хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна. Өмнөх аудитаар өгсөн Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг ил тод, хугацаанд нь байршуулж ажиллах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	1	-	-	-	1	-	-	-
Дүн	1	-	-	-	1	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Шалгагдагч байгууллага нь 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан жилийн 337.6 сая төгрөгийн дүнтэй 23/09;23/23-МГТБҮ тоот гэрээг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А-1/893 тоот албан бичгээр Ажлын байр түрээслэх зөвшөөрөл олгосон боловч тендер зарлаагүй шууд гэрээ байгуулсан байна.	1	337,668.0	-	-	1	337,668.0	-	-
Монгол Газрын тос боловсруулах үйлдвэрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин батлах тухай 4 дүгээр тогтоолд 2024 оны нийт зардлыг 8,578.3 сая төгрөгөөр баталснаас 12,298.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу нийт зардлын төлөвлөгөөг /элэгдлийн зардлаар/ 3,312.2 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.	1	3,312,160.9	-	-	1	3,312,160.9	-	-
МГТБҮ ТӨХХК-ийн зохион байгуулалтын бүтэц, орон тоог ТУЗ-ийн 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 15 дугаар тогтоолоор батлахдаа "Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын албатай, 3 орон тоотой ажиллуулахаар тогтоосныг хэрэгжүүлээгүй, дотоод хяналтын 2 ажилтныг томилсон боловч албыг байгуулаагүй байна.	1	-	-	-	-	-	1	-
Дүн	3	3,649,828.9	-	-	2	3,649,828.9	1	-
Нийт дүн	4	3,649,828.9	-	-	3	3,649,828.9	1	-